



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2023/72/НА-СА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2023 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 70342580      Цахим хаяг: <a href="mailto:erdeneb@audit.gov.mn">erdeneb@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716      Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: А.Сувдаа Утас: 70342495      Цахим хаяг: <a href="mailto:suvdaaa@audit.gov.mn">suvdaaa@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
Асуудлыг онцолсон хэсэг.....	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал.....	Error! Bookmark not defined.
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	5
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	13
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	16
4.1 Ерөнхий зүйл .....	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	18
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	18
Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно. ....	18
<b>5.2 Албан шаардлага</b> .....	18
Захирлын 2022 оны 12 дугаар сарын 14-ний А/59 тоот тушаалаар тооллогын комисс томилон тооллогыг хийсэн ч тавилга эд хогшил 569,360.0 төгрөгөөр илүү, номын фондыг 3,997,171.0 төгрөгөөр дутуу тоолсон, тооллогыг үнэн зөв хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 72, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийг зөрчсөн, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй. ....	18
<b>5.3 Зөвлөмж</b> .....	18
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББ	Нягтлан бодох бүртгэл



**БУЛГАН АЙМГИЙН  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-2580  
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.17 № 73

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

**БУЛГАН СУМЫН  
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
НЭГДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Э.ТҮВШИНМӨНХ ТАНАА**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Ерөнхий боловсролын нэгдүгээр сургууль 1 хөтөлбөр 15 зориулалт арга хэмжээний хүрээнд 2,938,141.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж 2,891,700.6 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд гүйцэтгэлийн үнэлгээний шалгалтын үр дүнд үр дүнгийн урамшуулал авах болзол хангасан 31 багш, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр IV түвшинд үнэлэгдэн Боловсролын ерөнхий газраас ирүүлсэн чиглэл шийдвэрийн дагуу үр дүнгийн болон нэмэлт урамшуулал олгосон байна.

Тайлант онд 99,185.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 318,278.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 417,463.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цахим ангитай болсонтой холбоотой байна.

D:/bichighereg/2023A4toot

006020078

## **Аудитын гол асуудал**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

## **Бусад мэдээлэл**

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

## **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл /төгрөгөөр/
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>140,937,382.38</b>	<b>171,791,535.36</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	35,042,308.46
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	35,042,308.46
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	35,042,308.46
31211	Төрийн сангийн харилцах	-	35,042,308.46
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	22,921,177.00	3,045,170.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,008,577.00	3,045,170.52
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	21,912,600.00	-
3351	Байгууллагаас авах авлага	21,912,600.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	115,202,005.38	133,704,056.38
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	11,273,998.00	20,702,845.00
35110	Тусгай зориулалттай материал	11,056,998.00	20,410,845.00
35130	Эм боох материал	217,000.00	292,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	103,928,007.38	113,001,211.38
35410	Бичиг хэргийн материал	784,000.00	1,222,000.00
35420	Аж ахуйн материал	73,904,886.00	87,826,164.00
35450	Барилгын засварын материал	1,214,000.00	3,727,900.00
35460	Хүнсний материал	15,063,888.00	5,802,889.00
35470	Бусад хангамжийн материал	12,961,233.38	14,422,258.38
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	2,814,200.00	-
36600	Бусад нөөц	2,814,200.00	-
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,112,164,572.04</b>	<b>5,287,690,423.26</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	5,112,164,572.04	5,287,690,423.26
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	4,627,144,155.66	4,809,513,756.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,624,013,517.00	4,622,251,717.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(360,746,393.01)	(473,918,457.57)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	330,158,608.56	565,847,715.06
39206	Хуримтлагдсан элэгдэл	(146,847,394.75)	(212,247,150.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	277,576,120.45	333,173,860.02
39208	Хуримтлагдсан элэгдэл	(120,802,943.43)	(149,329,914.51)
39209	Зам, гүүрийн байгууламж	-	99,139,512.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	(1,652,325.20)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,019,681.41	4,136,778.99
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,459,564.99)	(3,117,673.69)
39217	Ном	21,232,524.42	25,229,695.42
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	485,020,416.38	478,176,666.30
39301	Програм хангамж	7,554,860.00	9,554,860.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,944,443.62)	(8,788,193.70)
39303	Бусад биет бус хөрөнгө	479,410,000.00	477,410,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>5,253,101,954.42</b>	<b>5,459,481,958.62</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,862,187.81</b>	<b>432,072.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	7,862,187.81	432,072.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	7,862,187.81	432,072.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	7,400,097.81	-
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	462,090.00	432,072.00
41361	Байгууллагад төлөх өглөг	462,090.00	432,072.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>5,245,239,766.61</b>	<b>5,459,049,886.62</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	5,245,239,766.61	5,459,049,886.62
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,256,550,162.42	1,256,550,162.42
51101	Өмч: - төрийн	477,410,000.00	477,410,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,606,810,655.09	2,820,620,775.10

51210	Өмнөх үеийн үр дүн	2,606,810,655.09	2,606,989,455.09
51220	Тайлант үеийн үр дүн	-	213,631,320.01
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,381,878,949.10	1,381,878,949.10
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>5,253,101,954.42</u></b>	<b><u>5,459,481,958.62</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,364,115,428.19</b>	<b>3,229,801,381.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>24,749,365.13</b>	<b>301,908,381.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	24,749,365.13	301,908,381.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	24,749,365.13	301,908,381.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	24,749,365.13	301,908,381.50
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,339,366,063.06</b>	<b>2,927,893,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,986,140,300.00	2,414,940,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,414,940,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,986,140,300.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,953,662.00	15,150,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,953,662.00	150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	14,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	340,272,101.06	497,802,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,272,101.06	497,802,300.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,515,088,914.17</b>	<b>3,016,170,061.49</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,515,088,914.17</b>	<b>3,016,170,061.49</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,354,332,825.18	2,857,015,692.99
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,517,018,912.82	1,803,003,000.93
210101	Үндсэн цалин	945,762,945.32	1,317,269,801.48
210102	Нэмэгдэл	413,891,914.28	387,002,769.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,662,500.00	-
210104	Урамшуулал	115,701,553.22	98,730,430.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	193,430,605.50	215,328,637.88
210201	Тэтгэврийн даатгал	135,354,746.33	147,486,794.21
210202	Тэтгэмжийн даатгал	14,992,432.26	17,380,095.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,812,683.69	13,820,075.83
210204	Ажилгүйдлийн даатгал	2,837,232.81	3,404,859.69
210205	Эрүүл мэндийн даатгал	27,433,510.41	33,236,812.99
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	338,272,101.06	414,663,782.00
210301	Гэрэл, цахилгаан	14,513,303.06	25,489,656.00
210302	Түлш, халаалт	288,622,385.00	339,465,000.00
210303	Цэвэр, бохир ус	35,136,413.00	49,709,126.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,826,465.50	17,229,490.00
210401	Бичиг хэрэг	3,470,022.00	15,061,290.00
210402	Тээвэр, шатахуун	1,770,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	635,853.50	-
210404	Ном, хэвлэл	210,760.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,982,030.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	703,300.00	2,168,200.00
210408	Бараа материал акталсны зардал	54,500.00	-

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	54,812,324.00	106,462,553.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,280,700.00	1,752,134.40
210502	Хоол, хүнс	47,473,474.00	95,718,419.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,058,150.00	8,992,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,528,100.00	29,527,672.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,000.00	-
210604	Урсгал засвар	6,458,100.00	29,527,672.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	454,000.00	7,604,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,000.00	3,292,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	4,312,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	234,990,316.30	263,196,156.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,865,000.00	22,091,823.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,249,550.00	1,166,575.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	229,875,766.30	239,937,758.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	160,756,088.99	159,154,368.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	57,498,800.00	159,154,216.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,408,800.00	137,881,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,090,000.00	21,272,716.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	103,257,288.99	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,257,288.99	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	152.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	152.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(150,973,485.98)</b>	<b>213,631,320.01</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	-
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(150,973,485.98)</b>	<b>213,631,320.01</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,344,591,563.06</b>	<b>2,927,893,000.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,344,591,563.06</b>	<b>2,927,893,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,986,140,300.00	2,414,940,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	2,414,940,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,986,140,300.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	18,179,162.00	15,150,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,953,662.00	150,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,225,500.00	14,000,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	340,272,101.06	497,802,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,272,101.06	497,802,300.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,315,164,973.06</b>	<b>2,793,665,188.54</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,315,164,973.06</b>	<b>2,793,665,188.54</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,153,508,884.07</b>	<b>2,634,510,820.04</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,510,418,420.01	1,802,672,750.56
210101	Үндсэн цалин	939,162,452.51	1,317,583,687.21

210102	Нэмэгдэл	413,891,914.28	386,627,406.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	41,662,500.00	-
210104	Урамшуулал	115,701,553.22	98,461,656.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	193,430,605.50	225,095,579.58
210201	Тэтгэврийн даатгал	135,354,746.33	149,400,897.00
210202	Тэтгэмжийн даатгал	14,992,432.26	23,563,688.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,812,683.69	14,535,729.44
210204	Ажилгүйдлийн даатгал	2,837,232.81	3,469,830.33
210205	Эрүүл мэндийн даатгал	27,433,510.41	34,125,434.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	338,272,101.06	414,663,782.00
210301	Гэрэл, цахилгаан	14,513,303.06	25,489,656.00
210302	Түлш, халаалт	303,813,800.00	339,465,000.00
210303	Цэвэр, бохир ус	19,944,998.00	49,709,126.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,795,135.50	105,000.00
210401	Бичиг хэрэг	1,614,922.00	-
210402	Тээвэр, шатахуун	1,044,000.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	635,853.50	-
210404	Ном, хэвлэл	210,760.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,627,400.00	105,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,662,200.00	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	62,133,482.00	86,314,620.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	962,700.00	-
210502	Хоол, хүнс	57,662,782.00	86,314,620.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,508,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	17,181,710.00	7,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	13,100,300.00	-
210602	Тавилга	516,410.00	-
210604	Урсгал засвар	3,565,000.00	7,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,360,000.00	13,653,665.50
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,360,000.00	3,292,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	10,361,265.50
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	17,917,430.00	85,005,422.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,558,930.00	61,300,205.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,358,500.00	23,705,217.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>161,656,088.99</b>	<b>159,154,368.50</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	58,398,800.00	159,154,216.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,408,800.00	137,881,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,990,000.00	21,272,716.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	103,257,288.99	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	103,257,288.99	-
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	-	152.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	152.50
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>29,426,590.00</u></b>	<b><u>134,227,811.46</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>29,426,590.00</b>	<b>99,185,503.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>29,426,590.00</b>	<b>99,185,503.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	29,426,590.00	99,185,503.00
222001	Тоног төхөөрөмж	16,328,300.00	99,185,503.00
223001	Бусад хөрөнгө	13,098,290.00	-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(29,426,590.00)</u>	<u>(99,185,503.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	35,042,308.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	35,042,308.46

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,256,550,162.42	1,381,878,949.10	2,757,784,141.07		5,396,213,252.59
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,256,550,162.42</b>	<b>1,381,878,949.10</b>	<b>2,757,784,141.07</b>	-	5,396,213,252.59
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(150,973,485.98)		(150,973,485.98)
C08	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,256,550,162.42</b>	<b>1,381,878,949.10</b>	<b>2,606,810,655.09</b>	-	5,245,239,766.61
D01	<b>2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,256,550,162.42</b>	<b>1,381,878,949.10</b>	<b>2,606,810,655.09</b>	-	5,245,239,766.61
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	178,800.00		178,800.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,256,550,162.42</b>	<b>1,381,878,949.10</b>	<b>2,606,989,455.09</b>	-	5,245,418,566.61
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	213,631,320.01		213,631,320.01
D09	<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,256,550,162.42</b>	<b>1,381,878,949.10</b>	<b>2,820,620,775.10</b>	-	5,459,049,886.62

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,938,141,400.00	2,891,700,539.04
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,938,141,400.00	2,891,700,539.04
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,767,766,300.00	2,732,546,323.04
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,830,327,800.00	1,802,672,750.56
210101	Үндсэн цалин	1,418,857,700.00	1,317,583,687.21
210102	Нэмэгдэл	362,736,900.00	386,627,406.95
210104	Урамшуулал	48,733,200.00	98,461,656.40
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	228,791,300.00	225,095,579.58
210201	Тэтгэврийн даатгал	155,578,000.00	149,400,897.00
210202	Тэтгэмжийн даатгал	18,303,400.00	23,563,688.67
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,642,600.00	14,535,729.44
210204	Ажилгүйдлийн даатгал	3,660,700.00	3,469,830.33
210205	Эрүүл мэндийн даатгал	36,606,600.00	34,125,434.14
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	413,663,900.00	414,663,782.00
210301	Гэрэл, цахилгаан	25,659,200.00	25,489,656.00
210302	Түлш, халаалт	339,465,000.00	343,470,860.00
210303	Цэвэр, бохир ус	48,539,700.00	45,703,266.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	150,000.00	105,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,000.00	105,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	87,357,100.00	86,314,620.00
210502	Хоол, хүнс	87,357,100.00	86,314,620.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,000,000.00	7,000,000.00
210604	Урсгал засвар	7,000,000.00	7,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	16,365,900.00	13,554,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	3,292,400.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	16,365,900.00	10,262,150.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	184,110,300.00	183,140,040.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,561,500.00	159,184,823.50
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	24,548,800.00	23,955,217.40
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	170,375,100.00	159,154,216.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	170,375,100.00	159,154,216.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	149,099,400.00	137,881,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,275,700.00	21,272,716.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	2,912,743,000.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	2,414,940,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	-	2,414,940,700.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	-	497,802,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	-	497,802,300.00
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		<b>35,042,308.46</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	126.00	126.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	85.00	85.00
620003	Үйлчлэх ажилтан	40.00	40.00

<b>63</b>	<b>СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)</b>	1,457.00	1,457.00
<b>630</b>	<b>ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД</b>	1,457.00	1,457.00
630001	Төрийн өмчит ЕБС	1,457.00	1,457.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>126.00</b>	<b>126.00</b>
650004	СЭБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	86.00	86.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	40.00	40.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,150,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,150,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,150,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,150,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	150,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,150,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,150,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	150,000.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Тайлант онд тус байгууллага “Сургалтын таатай орчинд хүүхэд бүрийг төрөлх эх орон, Монгол ёс заншлаараа бахархдаг, боловсролтой, хүмүүнлэг иргэн болгон хөгжүүлнэ” зорилгын хүрээнд 5 зорилтыг дэвшүүлэн ажилласан байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоол, заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг хийж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 тоот захирамжаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 206,380.0 мянган төгрөгөөр буюу 3.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	35,042.31	35,042.31
Авлага	22,921.18	3,045.17	-19,876.01
Бараа материал	115,202.01	133,704.06	18,502.05
Үндсэн хөрөнгө	5,112,164.57	5,287,690.42	175,525.85
<b>Нийт хөрөнгө</b>	<b>5,253,101.95</b>	<b>5,459,481.96</b>	<b>206,380.00</b>
Өр төлбөр	7,862.19	432.07	-7,430.12
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	5,245,239.77	5,459,049.89	213,810.12
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>5,253,101.95</b>	<b>5,459,481.96</b>	<b>206,380.00</b>

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант онд 99,185.5 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч 318,278.1 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч нийт 417,463.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь цахим ангитай болсонтой холбоотой байна.

БСШУЯ-аас 193,976.6 мянган төгрөг, дахин үнэлгээгээр 3,165.0 мянган төгрөг, ОНХС-аас санхүүжсэн хөл бөмбөгийн талбай 99,139.5 мянган төгрөг, өмнөх онд авлага 17,567.0 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө өссөнөөс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,812,539.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 81,631.9 мянган төгрөгөөр бууруулж, 2,730,907.2 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол 181,835.8 мянган төгрөгөөр хийгдсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,414,940.7 мянган төгрөгийн, орон нутгаас 497,802.3 мянган төгрөгийн, санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,891,700.5 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 35,042.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан байна.

### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биел элт
1	80111	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	421,663.90	421,663.70	-	100%
2	80112	Нийтлэг үйлчилгээ	76,138.40	76,138.40	-	100%

3	81834	Боловсролын стандарт, сургалт	1,785,177.10	1,765,214.40	18,812.6	98%
4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	6,546.30	6,546.30	-	100%
5	80312	Сургалт семинар	3,273.20	3,273.20	-	100%
6	80823	Хоригдлуудын ЭМДШ	7,528.30	7041.0	487.3	99%
7	81801	Үдийн цай хөтөлбөр	149,099.40	137881.5	11,217.9	100%
8	81806	Дотуур байрны үйлчилгээ	120,769.20	119,719.5	1,049.60	99%
9	81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	85,415.00	85,415.00	127.90	99%
10	81823	Боловсролын байгууллагын багш,	14,729.30	14,729.30	-	100%
11	81835	Сургалтын хэвийн үйл ажиллагаа	234,575.20	234,150.80	424,30	99%
12	81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	14,900.00	14,222.40	632.70	95%
13	81848	Сурах бичгийн түрээс	5,111.30	3,292.4	2,290.0	64%
14	83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	2,995.30	2,995.30	-	100%
Нийт			2,928,221.90	2,892,850.48	35,042.3	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 1,150.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг хичээл үйлдвэрлэлийн зардалд 150.0 мянган төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 1,000.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Сувдаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган сумын ерөнхий боловсролын Нэгдүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвийн 2,938,141.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 44,072.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 92,603.7 мянган төгрөгийн орлого, 135,410.8 мянган төгрөгийн зарлага, 4 удаагийн 55,245.4 мянган төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй, худалдан авалтын мэдээллийг өссөн дүнгээр мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.4, 6.4.5, 6.4.8, Засгийн газрын 2016 оны 29

дүгээр тогтоолын хавсралтын 3.2.9, 3.2.10 -т заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, алдааг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах талаар албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цахим бус дэлгүүрээс 16,100.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн нь Хэмнэлтийн тухай хуулийн 14.4-ийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь:

Хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна. Зөвлөмжийн биелэлтийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 01/79 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					100
Албан шаардлага	4	161,700.0	4	161,700.0	100
Зөвлөмж	4	133,500.0	4	133,500.0	
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>295,200.0</b>	<b>8</b>	<b>295,200.0</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тус байгууллагын хөрөнгө бэлтгэх явц болон цахим дэлгүүрээс худалдан авалт хийснийг анхаарах

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

---

Аудитаар нийт 5,871.1 мянган төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснийг аудитын явцад залрууллаа.

Үүнд: Бараа материалыг данс бүртгэлд бүртгэхдээ алдаатай бүртгэсэн, Үндсэн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрөхдөө огноог алдаатай бүртгэснээс тайланд нөлөө үзүүлсэн.

Аудитаар нийт 10,087.3 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 4,566.5 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 5,520.8 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 5.2 Албан шаардлага

Захирлын 2022 оны 12 дугаар сарын 14-ний А/59 тоот тушаалаар тооллогын комисс томилон тооллогыг хийсэн ч тавилга эд хогшил 569,360.0 төгрөгөөр илүү, номын фондыг 3,997,171.0 төгрөгөөр дутуу тоолсон, тооллогыг үнэн зөв хөтлөөгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 72, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-ийг зөрчсөн, тохиолдсон байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалтай холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд олгох зардлын нормоос 1-3,5 сард илүү, 4, 9-12 сард дутуу тооцон зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолын 2-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд олгох зардлын нормоор тооцон олгох.

#### 2. Зардлын холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Ажил олгогчийн нийгмийн даатгалын зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил руу шилжүүлэн зарцуулсан нь Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын хавсралтын 4.1-т заасныг бүрэн хэрэгжүүлээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалын хавсралтын 4.1-т заасныг бүрэн хэрэгжүүлэх.

---

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхиадуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалыг данс бүртгэлд буруу бүртгэсэн	1	2,814.20	0	0	1	2,814.20	1	2,814.20	0	0	0	0
Үндсэн хөрөнгийг орлого авахдаа огноог алдаатай бүртгэн элэгдэл тооцоогүй	1	3,056.91			1	3,056.91	1	3,056.91				
Дүн	2	5,871.11	0	0	2	5,871.11	2	5,871.11	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Ажил олгогчийн нийгмийн даатгалын зардлаас цалин хөлс болон нэмэгдэл урамшил руу шилжүүлэн зарцуулсан	1	9,766.94					1	9,766.94				
Хүүхдийн хоолны зардлыг нэг хүүхдэд олгох зардлын нормоор олгоогүй	1	5,520.80					1	5,520.80				
Үндсэн хөрөнгийн тооллогыг үнэн зөв хөтлөөгүй	1	4,566.53			1	4,566.53						
Дүн	2	10,087.33	0	0	1	4,566.53	1	5,520.80	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд таван сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй	1	283,259.93			1	283,259.93		
Дүн	1	283,259.93	0	0	1	283,259.93	0	0
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй	1	16,100.00			1	16,100.00		
Дүн	1	16,100.00	0	0	1	16,100.00	0	0
Нийт дүн	2	299,359.93	0	0	2	299,359.93	0	0

-оОо-